

БАТЛАВ  
Д.НАЦАГДОРЖИЙН АЗРЭМЖИТ  
УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН  
ТӨВ НОМЫН САНГИЙН  
ЗАХИРАЛ ӨСӨРДЭНЭБАТ

2018 оны 01 сарын 10 өдөр

9077847

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН "САХИЛГА ХАРИУЦЛАГА,  
ДЭГ ЖУРМЫГ ЧАНГАТГАХ ТУХАЙ" 01 ДҮГЭЭР АЛБАН ДААЛГАВРЫГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2018 оны 01 дүгээр сарын 20

Улаанбаатар хот

| д/д                                                     | Хэрэгжүүлэх ажил                                                                                                                                                                                                        | Хугацаа             | Гүйцэтгэх ажилтан                                                                            |
|---------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|----------------------------------------------------------------------------------------------|
| 1                                                       | 2                                                                                                                                                                                                                       | 3                   | 4                                                                                            |
| <i>Нэг. Сахилга хариуцлага, ёс зүйн чиглэлээр</i>       |                                                                                                                                                                                                                         |                     |                                                                                              |
| 1                                                       | Байгууллагын "Ёс зүйн дүрэм"-ийг шинэчлэн батлуулах, мөрдүүлэх                                                                                                                                                          | 1-р улиралд         | Захиргаа, удирдлагын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч                              |
| 2                                                       | Ёс зүйн зөрчил гаргасан албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах, гаргасан шийдвэрийг ил тод мэдээлэх                                                                                                                | Тухай бүр           | Захиргаа, удирдлагын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч                              |
| 3                                                       | Албан хаагчдын хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээг ажлын гүйцэтгэлтэй уялдуулж үнэлж дүгнэх                                                                                                                             | Хагас, бүтэн жилээр | Тасаг, салбарын эрхлэгч нар                                                                  |
| 4                                                       | Ажилтан албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, сахилга хариуцлагыг дээшлүүлж зөрчил дутагдал гаргасан ажилтнуудад сахилга хариуцлагыг тооцож хэвших | Тухай бүр           | Захиргаа, удирдлагын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Тасаг, салбарын эрхлэгч нар |
| <i>Хоёр. Төсвийн сахилга батыг сайжруулах чиглэлээр</i> |                                                                                                                                                                                                                         |                     |                                                                                              |
| 1                                                       | Байгууллагын санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг хангаж нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, УИХ, Засгийн газар, Сангийн сайдын баталсан холбогдох заавар журмыг мөрдөж ажиллах                           | Жилдээ              | Захиргаа, санхүү                                                                             |
| 2                                                       | Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын явц, чанар, үр дүнд хийх хяналт шинжилгээний ажлыг эрчимжүүлэх                                                                                                                         | Жилдээ              | Захиргаа, санхүү                                                                             |
| 3                                                       | Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, захиран зарцуулалтанд хяналт тавих, дотоод хяналтыг сайжруулах                                                                                           | Тухай бүр           | Өмч хамгаалах байнгын комисс                                                                 |

| 1                                             | 2                                                                                                                                                                                                                                                                                      | 3                     | 4                           |
|-----------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------------|
| Гурав. Төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр |                                                                                                                                                                                                                                                                                        |                       |                             |
| 1                                             | Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, нийслэлийн хэмжээнд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг богиносгох, зөрчил, дутагдал гаргасан албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцуулан, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж ажиллах | Тухай бүр             | Захиргаа, санхүү            |
| 2                                             | Албан даалгаврыг хэрэгжүүлж үр дүнг тайлагнах                                                                                                                                                                                                                                          | Сар бүрийн 03-ны өдөр | Холбогдох удирдлагууд       |
| 3                                             | Албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдэж буй ажлын талаар номын сангийн вэб хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах                                                                                                                                             | Тухай бүр             | Маркетинг, инновацийн тасаг |

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:  
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН АЛБАНЫ ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

М.ОТГОНБАЯР